

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	16
Байхгүй	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.АЙЛАНЫШ ТАНАА**

2022-02-25 № 239
танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Dugnelt-TA (1)

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Dugnelt-TA (1)

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41563708.78</u>	<u>21717235.90</u>
33	АВЛАГА	3626905.58	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3626905.58	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37936803.20	21717235.90
354	Хангамжийн материал	37936803.20	21717235.90
35420	Аж ахуйн материал	33440.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	405960.00	0.00
35460	Хүнсний материал	7188621.00	6884352.70
35470	Бусад хангамжийн материал	30308782.20	14832883.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>470662554.24</u>	<u>453642959.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	470662554.24	453642959.13
392	Биет хөрөнгө	440662554.24	423642959.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	443971234.84	443971234.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18237674.19	-27920683.23
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19589126.00	18337581.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15637581.59	-13773152.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25901613.00	15885680.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15273717.82	-14507254.81
39209	Зам, гүүрийн байгууламж	349554.00	349554.00
39217	Ном	0.00	1300000.00
393	Биет бус хөрөнгө	30000000.00	30000000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30000000.00	30000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>512226263.02</u>	<u>475360195.03</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>512226263.02</u>	<u>475360195.03</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	512226263.02	475360195.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	123710427.00	123710427.00
51101	Өмч: - төрийн	123710427.00	123710427.00
512	Хуримтлагдсан үр дүн	131275448.18	94409380.19
51210	Өмнөх үеийн үр дүн	131275448.18	131275448.18
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-36866067.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	257240387.84	257240387.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>512226263.02</u>	<u>475360195.03</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	294,975,416.00	286,347,545.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,440.00	111,385.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,440.00	111,385.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,440.00	111,385.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,440.00	111,385.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	294,941,976.00	286,236,160.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	279,879,776.00	270,555,755.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,793,176.00	145,455.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278,086,600.00	270,410,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,489,405.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,489,405.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,062,200.00	11,191,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,062,200.00	11,191,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	303,894,072.99	314,462,604.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,894,072.99	314,462,604.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,645,982.99	306,597,457.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,319,482.46	216,616,003.58
210101	Үндсэн цалин	197,118,082.46	197,887,303.58
210104	Урамшуулал	16,125,800.00	9,653,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,075,600.00	9,075,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,398,900.00	28,689,800.00
210201	Тэтгэврийн даатгал	21,391,700.00	20,189,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,800.00	2,125,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,400.00	1,700,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	450,400.00	425,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,503,600.00	4,250,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,051,147.50	10,496,960.00
210301	Гэрэл, цахилгаан	88,200.00	-
210302	Түлш, халаалт	13,962,947.50	10,496,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,360,200.00	4,439,025.00
210401	Бичиг хэрэг	394,100.00	101,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,472,000.00	2,540,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	617,000.00	736,500.00

210404	Ном, хэвлэл	100,000.00	145,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	777,100.00	735,225.00
2105	Норматив зардал	10,535,964.00	15,852,728.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,400.00	96,900.00
210502	Хоол, хүнс	9,980,934.00	15,246,728.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465,630.00	509,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	14,388,399.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,738,399.00
210604	Урсгал засвар		650,000.00
2107	Томилолт, зочны зардал	196,000.00	116,400.00
210702	Дотоод албан томилолт	196,000.00	116,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	545,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		145,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,334,289.03	15,452,642.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	328,000.00	4,188,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,006,289.03	11,264,042.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,248,090.00	7,865,147.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,038,326.00	7,837,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,038,326.00	7,837,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,209,764.00	28,147.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,209,764.00	28,147.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(8,918,656.99)</u>	<u>(28,115,059.99)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8,751,008.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	8,751,008.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(8,751,008.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(8,918,656.99)</u>	<u>(36,866,067.99)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	131,275,448.18	512,226,263.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	131,275,448.18	512,226,263.02
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	131,275,448.18	512,226,263.02
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	131,275,448.18	512,226,263.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	131,275,448.18	512,226,263.02
D08	Тайлант үеийн үр дүн			-36,866,067.99	-36,866,067.99
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,710,427.00	257,240,387.84	94,409,380.19	475,360,195.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>293148800.00</u>	<u>286090705.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293148800.00	286090705.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	278086600.00	270410300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278086600.00	270410300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4489405.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4489405.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15062200.00	11191000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15062200.00	11191000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>291804900.00</u>	<u>283240705.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291804900.00	283240705.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283556810.00	275375558.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225178300.00	212989098.00
210101	Үндсэн цалин	199976900.00	194260398.00

210104	Урамшуулал	16125800.00	9653100.00
210105	Гэрээт ажлын хөлс	9075600.00	9075600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30398900.00	28689800.00
210201	Тэтгэврийн даатгал	21391700.00	20189200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2251800.00	2125100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1801400.00	1700100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	450400.00	425000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4503600.00	4250400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13970200.00	10091000.00
210301	Гэрэл, цахилгаан	88200.00	0.00
210302	Түлш, халаалт	13882000.00	10091000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3230200.00	4177800.00
210401	Бичиг хэрэг	264100.00	101800.00
210402	Тээвэр, шатахуун	1472000.00	2540000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	617000.00	736500.00
210404	Ном, хэвлэл	100000.00	145500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	777100.00	474000.00
2105	Нормативт зардал	9675210.00	15664860.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89400.00	96900.00
210502	Хоол, хүнс	8421510.00	14942460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1164300.00	625500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	650000.00
210604	Урсгал засвар		650000.00
2107	Томилолт, зочны зардал	196000.00	116400.00
210702	Дотоод албан томилолт	196000.00	116400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450000.00	545500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		145500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	458000.00	2451100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	458000.00	2451100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8248090.00	7865147.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3038326.00	7837000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3038326.00	7837000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5209764.00	18742.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5209764.00	18742.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	9405.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		9405.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1343900.00</u>	<u>2850000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1343900.00	2850000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1343900.00	2850000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	1343900.00	2850000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1343900.00	2850000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1343900.00</u>	<u>-2850000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	281601300.00	281582558.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	281601300.00	281582558.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273764300.00	273745558.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212997300.00	212989098.00
210101	Үндсэн цалин	194268600.00	194260398.00
210104	Урамшуулал	9653100.00	9653100.00
210105	Гэрээт ажлын хөлс	9075600.00	9075600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28689800.00	28689800.00
210201	Тэтгэврийн даатгал	20189200.00	20189200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2125100.00	2125100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1700100.00	1700100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425000.00	425000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4250400.00	4250400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10541000.00	10541000.00
210301	Гэрэл, цахилгаан	530000.00	450000.00
210302	Түлш, халаалт	10011000.00	10091000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3297800.00	3297800.00
210401	Бичиг хэрэг	101800.00	101800.00
210402	Тээвэр, шатахуун	1840000.00	1840000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	736500.00	736500.00
210404	Ном, хэвлэл	145500.00	145500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	474000.00	474000.00
2105	Нормативт зардал	15675400.00	15664860.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96900.00	96900.00
210502	Хоол, хүнс	14953000.00	14942460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	625500.00	625500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	650000.00	650000.00

210604	Урсгал засвар	650000.00	650000.00
2107	Томилолт, зочны зардал	116400.00	116400.00
210702	Дотоод албан томилолт	116400.00	116400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	545500.00	545500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	145500.00	145500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1251100.00	1251100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1251100.00	1251100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7837000.00	7837000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7837000.00	7837000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7837000.00	7837000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	281601300.00	281582558.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	270410300.00	270391558.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	270410300.00	270391558.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11191000.00	11191000.00
132001	Орон нутгийн төсвөөс	11191000.00	11191000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1.00	1.00
630001	Төрийн өмчит ЕБС	1.0	1.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.0	24.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4489405.00	4480000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4489405.00	4480000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4489405.00	4480000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1989405.00	1980000.00

210402	Тээвэр, шатахуун	700000.00	700000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	189405.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1100000.00	1100000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2500000.00	2500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2500000.00	2500000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	9405.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		9405.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4489405.00	4480000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4489405.00	4480000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4489405.00	4480000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Тухайн багт амьдран суудаг бага боловсрол эзэмших сургуулийн насны хүүхдүүдэд бага боловсрол эзэмшүүлэх, сургуулийн насны хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах ба тэдэнд чанартай боловсрол олгох чиг үүрэг бүхий үйл ажиллагаа явуулдаг байгууллага.

Зорилго, зорилт нь сурагчдад бага боловсролыг чанартай хүргэх, суралцагчдыг зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй, сурган хүмүүжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас 2019, 2020 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдсэн байна..

Тус байгууллагын дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 303.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36.8 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	3,626.9	0	-3,626.9
Урьдчилгаа			
Бараа материал	37,936.8	21,717.2	-16,219.5
Үндсэн хөрөнгө	470,662.6	453,642.9	-17,019.7
Нийт хөрөнгө	<u>512,226.3</u>	<u>475,360.2</u>	<u>-36,866.1</u>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	512,226.3	475,360.2	36,866.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>512,226.3</u>	<u>475,360.2</u>	<u>36,866.1</u>

Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 3.6 сая төгрөгөөр буурч оны эцэст авлагагүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21.7 сая төгрөг болж 16.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 27.8 сая төгрөгийн материал худалдан авч, 44.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17.0 сая төгрөгөөр буурсан нь 1.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн ном худалдаж авч, Аймгийн ИТХ-ын 2021 оны 133 тоот тогтоолын дагуу 2.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 10.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл акталж, үндсэн хөрөнгөд 11.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 286.4 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар хасагдсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, хөрөнгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт болон урсгал санхүүжилт байна.

Нийт зардал 314.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 10.6 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 278.5 сая төгрөг, тодотгосон төсөв 281.6 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 3.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 18.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ 2.5 сая төгрөгөөр нэмэгдэж, норматив зардал 16.0 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 2.0 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлын төсвийг дутуу суулгасантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь тайлант онд 281.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 281.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 281.6 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 75.6 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 3.7 хувийг тогтмол зардал, 1.2 хувийг хангамж бараа материалын зардал, 5.6 хувийг норматив зардал, 3.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.04 хувийг томилолт зочны зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 4.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна. Үүнээс хангамж бараа материалын зардалд 2.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 2.5 сая төгрөгийг зарцуулж, 0.009 сая, төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалин, НДШ-ийн зардал, тогтмол зардал, хоол, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал зардалд нийтдээ 275.0 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.6 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс мөнгө төвлөрүүлээгүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд нийт 286.0 сая төгрөгийн 20 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 17 мэдээллийг хугацаандаа байршуулж, 1 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.8 сая төгрөгийн зөрчил илэрч үүнээс 0.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 6.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 0.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 6.6 сая төгрөгийн төсвийн 10 хувь 0.6 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцоолж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

4.4 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, талагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлан онд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 0.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3.5 сая төгрөг, норматив зардал 0.005 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардад 0.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.8 сая төгрөг, томилолтын зардал, норматив зардалд 0.1 сая төгрөг, нийт 6.2 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн	Үүнээс			
			Залруулга	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
						/сая төгрөгөөр/

		Тоо	Дүн								
1	Цэнгэл сумын ерөнхий боловсролын 3-р сургууль	2	6.8					1	0.6	1	6.2